

МОНГОЛ, АНУ-ЫН ХООРОНД ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ОРОЛДЛОГУУД

Ц.Алтангэрэл*

***Abstract:** The article discusses a series of events and actions occurred during the historical period starting from the time Mongolia declared its independence from the Manchu subjugation through the moment the United States recognized its independence. In doing so, the author conducts contextual analyses of official primary sources in which the U.S. government expressed its intention and position to establish diplomatic and trade relations between the two countries, the main vision behind the 1924 agreement concluded between the Soviet Union and the Middle Kingdom in Beijing, the goal and meaning of U.S. Vice President Henry Wallace's visit to Mongolia, the outcome of the Yalta Conference as well as the Middle Kingdom's recognition of Mongolia's independence.*

***Key words:** Bogd Khanate Mongolia, Middle Kingdom, Diplomatic relations and negotiations, Jebtsundamba, United States*

XX зууны эхэн үеийн Монгол, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох хүчин чармайлт:

Монгол орон Манж Чин Улсын эрхшээлээс 1911 оны эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд ангижирч, тусгаар тогтнол, эрх чөлөөгөө зарлан тунхаглаж, түүнийгээ дэлхий дахинд хүлээн зөвшөөрүүлэхийн тулд их гүрэн АНУ-тай дипломат харилцаа тогтоон, тус улсаар дэмжүүлэхийг эрмэлзэж байв. АНУ-тай харилцаа тогтоож, хүлээн зөвшөөрүүлэх зорилго бүхий анхны захидлыг Богд хаант Монгол Улсын засгийн газар 1912 оны 10-р сарын 9-нд илгээжээ. Тус захидалд: “Бидний Монголчууд газар нутаг, шашин суртал, ёс журмаа хадгалах зорилгоор Чин Улсаас салж бүрэн эрхт тусгаар тогтносон Улсыг байгуулав. Монголын шарын шашны тэргүүн Жавзандамба хутагтыг төр, шашны хэргийг мандуулахаар Монголын эзэн хаанд өргөмжилж Олноо өргөгдсөний тэргүүн цолыг хүртээв. Энэхүү мэдээллийг гадаад орнуудын засгийн газарт хүргэхийг хичээнгүйлэн хүснэ. Бусад засгийн газарт энэхүү мэдээллийг хүргэхээс гадна үүнийг хүлээн авмагц, танай засгийн газраас биднийг хүлээн зөвшөөрч, гэрээ байгуулан, найрамдлыг зузаатган, худалдаа хийх хүсэлтийг уламжлахыг хүснэ”²²-

* ШУА-ийн ОУХХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), altangerelts@mas.ac.mn

² Р. Болд “Монголын тусгаар тогтнол ба Америкийн нэгдсэн улс” УБ 2008, 360-р тал

гэж бичжээ. АНУ-ын засгийн газарт хүргэх энэхүү Богд хааны тамгатай бичгийг Харбинд суугаа АНУ-ын консул Меанардад 1912 оны 12-р сарын 13-д гардуулсан нь Монгол Улс, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох анхны оролдлого байв.

Богд Хаант Монгол Улс тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэхээр АНУ-тай харилцаа тогтоох хүсэлт гаргасан нь АНУ-ын Ази дахь гадаад бодлогын үндэс болох “Хятадын газар нутаг, засаг захиргааны бүрэн бүтэн байдлыг хадгалах” гэсэн зарчимтай зөрчилдсөн юм. Иймд Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, Хятадтай таагүй харьцаанд орохоос АНУ сэрэмжилсэн байна. Тийнхүү АНУ-ын Ерөнхийлөгч Вүүдров Вильсон “Гадаад Монголын тусгаар тогтнолыг Орос хүлээн зөвшөөрсөн нь буруу зүйл болсон, АНУ ийм буруу зүйл хийхгүй” гэж үзэж Богд Хаант Монгол Улсын харилцаа тогтоох тэрхүү санал, санаачилгад нааштай хариу өгөөгүй юм.

Хятадад элчин сайдаар ажиллаж байсан, АНУ-ын дипломатч, Монгол, Төвд судлаач Вильям Вүүдвилл Рокхилл³ /1853-1914/ Оросоор дамжин Хятад явах замдаа Хүрээнд 1913 оны 12-р сарын 9-15-нд долоо хоножээ. В. Рокхилл шинээр тусгаар тогтносон Монгол орон бүрэн эрхт байдлаа дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудаар хүлээн зөвшөөрүүлэх маш их эрмэлзэлтэй байгааг ухамсарлаж байжээ. 1913-1914 онд Орост айлчилж байсан сайн ноён хаан Намнансүрэн тэргүүтэй төлөөлөгчид “Орос, Хятадын тунхаг бичгийн” талаар Монголын байр суурийг илэрхийлсэн ноот бичгийг АНУ-ын ЭСЯ-нд хүргүүлжээ. Элчин сайд Уилсон тэрхүү ноотыг хүлээн авч Засгийн газартаа илгээсэн байна. Эдгээр үйл ажиллагаанууд нь Богд хаант Монгол Улс, АНУ-тай харилцаа тогтоох удаа дараагийн оролдлогуудын нэг юм.

Монголын Засгийн газраас АНУ-тай харилцаа тогтоох гуравдахь захидлыг 1914 оны 2-р сарын 29-нд илгээсэн байна. Уг захидалд: “...манай Монгол Улс газар орон, шашин төр эзнээ алдахгүй сахих учир Чин Улсаас салаад шашны эзэн-Богд эзэн хаанд өргөмжилж тус улс төр байгуулаад бас олон гадаад их улсад гэрээ байгуулж, худалдаа нэвтрүүлэхээр албаны бичиг хоёр удаа явуулсан бөгөөд энэ завсар Оросын Элчин сайд ирж найрамдал, худалдааны гэрээ тогтоосон ч бусад олон гадаад улсаас өдгөө болтол хариу ирсэнгүй. Зүй нь манай улс урьдаар хүн явуулж олон учрыг нэвтрүүлж найрамдлын гэрээ байгуулбаас зохих боловч гагцхүү хэл мэдэхгүй, зам нэвтрүүлэхэд гачигдан боогдож бүхийгээс албаны тамгат бичиг үйлдэж эрхэм их Мей улсын засгийн газарт илгээв. Олдвоос улс төрийн хэргийг хэлэлцэж чадах сайн хүн манай нийслэл хүрээнээ ирүүлж гэрээ байгуулан худалдаа нэвтрүүлж тус олгомуй хэмээхээс гадна түр хариу ирүүлэхийг эрмэлзмүй.”⁴-гэж бичжээ.

³ Рокхилл төвд, монгол хэлтэй америкийн анхны дипломатч байсан бөгөөд 1888-1889 онд Төвд болон Өвөр Монголоор аялжээ. Монгол орны тухай “Лам нарын орон”, “Монгол, Төвдөөр аялсан тэмдэглэл” зэрэг хэд хэдэн ном өгүүлэл хэвлүүлжээ. Рокхилл Хятад, Төвд, Монголтой холбоотой 6000 орчим ном бүхий хувийн цуглуулгаа АНУ-ын Конгрессын номын санд хандивлажээ.

⁴ Р. Болд “Монголын тусгаар тогтнол ба Америкийн нэгдсэн улс” УБ 2008, 361-р тал

Богд хаант Монгол Улсын засгийн газраас илгээсэн энэхүү захидлыг Бээжин дэх АНУ-ын Элчин сайдын яам хүлээн авч цааш нь Засгийн газартаа уламжилсан байна. Гэвч АНУ-ын Засгийн газраас “Монголын Засгийн газрын харилцаа тогтоох хүсэлтийг эелдгээр татгалз, хариу өгөхдөө Хятадын ГЯЯ-тай зөвлөлд” гэж зааварласан юм. АНУ-ын ЭСЯ-ны элчин зөвлөх Тенней энэ асуудлаар “Монголын гүн” цолтой швед иргэн Ф. Ларсонтой⁵ уулзаж ярилцсан байна. Ф. Ларсон АНУ нь Монголтой харилцаа тогтоовол Хятадын ашиг сонирхолд нийцнэ, учир нь Оросууд Монголоос Хятад руу гарч байгаа малын гаралтай түүхий эд, бусад бараа бүтэгдэхүүнд экспортын татвар оногдуулахад нь нөлөөлж байгаа, хэрвээ Монгол арьс шир, ноос, ноолуур зэрэг малын түүхий эд, бусад бараанууддаа экспортын татвар оногдуулбал Хятад, Монголын хоорондох харилцаа тасрах тул үүнээс сэргийлэх үүднээс Америкийн худалдааг Монголд өрнүүлэх хэрэгтэй гэж Теннейд хэлж байв. Ф.Ларсон Монголын Засгийн газар гадаад ертөнцтэй харьцахад ихээхэн туслалцаа үзүүлсэн хүн юм. 1915 оны Хиагтын гурван улсын хэлэлцээр эхлэхээс өмнө Монголын Засгийн газар Бээжинд суугаа өндөр хөгжилтэй орнуудын Элчин сайдын яамуудад хаяглан бичсэн захидлуудыг уламжилж өгөхийг хүсэж Оросын Ерөнхий консулд өгсөн боловч тэд захидлуудыг дамжуулалгүйгээр хав дарсан байна. Иймд тэдгээр захидлуудыг Ф. Ларсонд дамжуулж өгөхийг хүсэж түүнд өгсөн байна. Энэ үйл ажиллагааг Ларсон амжилттай сайн гүйцэтгэсэн юм.

1915 онд Өвөр Монголын Хаалган хот гадаадынханд нээлттэй болсон тулд тэнд АНУ консулын газраа нээжээ. Энэ нь Богд хаант Монгол Улстай худалдаа хийх боломжийг АНУ-д олгосон байна. Хаалганд АНУ консулын газраа байгуулсан зорилго нь Монголтой худалдаа, наймаа хийхэд бүхий л талаас туслалцаа үзүүлэх, тэдгээр газар нутагт Америкийн ашиг сонирхлыг хамгаалах явдал байв. Америкийн худалдаачид Монголд худалдаа, арилжаа хийх нь ашигтай бизнес гэж үзэж байсан тул Бээжинд АНУ-ын элчин сайдаар ажиллаж байсан Рейнш, Хүрээнд АНУ-ын консулын газрыг байгуулах саналыг Засгийн газартаа хэд хэдэн удаа тавьж байсан боловч АНУ-ын Засгийн газар шаардлагагүй гэж үзжээ. Хаалган хот Монголыг цай, бүс бараа зэрэг өргөн хэрэглээний бараа таваараар хангадаг газар байлаа. Монголтой худалдаа хийх сонирхолтой олон арван пүүс, компаниуд үйл ажиллагаагаа явуулж байв. 1915 онд “The Mongolia Trading Company”, “Anderson, Meyer & Company” зэрэг пүүс, компаниуд Хүрээ, Улиастайд төлөөлөгчийн газраа байгуулсан бөгөөд 1918-1923 онуудад “Beijing Mongolor Mining Company”, “China American Trading Co”, Benjamin Rocklin”, F.A.Larson & Company” зэрэг пүүсүүд Хүрээ, Ховд, Улиастай зэрэг газруудад төлөөлөгчийн газраа нээж ажиллуулж байв. Эдгээр пүүсүүд Хүрээнд “Американ дэнж” нэртэй худалдааны төвийг байгуулсан байна. Энэ нэр өнөөг хүртэл хэрэглэгдэж байна. Тэнд америкчуудаас гадна, орос, монгол, хятад гээд янз бүрийн улсууд хөлсөөр ажиллаж байжээ. Ийнхүү АНУ,

⁵ Ларсон гүн хэмээн алдаршсан Август Ларсон (1870-1957) нь Шведийн сургааль номлогч, худалдаачин, дипломат хүн байсан. Монгол хэл сайн сурч Монголын төр засгийн удирдлагад байсан хүмүүсийн зөвлөхөөр ажиллаж, Монгол улсын гүн цол хэргэмийг Богд хаанаас хүртэж байв. Монголын тухай түүний анхны ном болох “Монгол ба монголчуудын дунд миний амьдрал” хэмээх ном нь хамгийн ихээр дэлгэрэн тарсан бөгөөд олон хэл дээр орчуулагдан гарсан юм.

Монголын хооронд худалдааны үйл ажиллагаа эхэлж нэлээд эрчээ авч байсан боловч Монгол оронд Ардын хувьсгал гарч Зөвлөлтийн нөлөө хүчтэй болсон учраас АНУ-ын худалдаа, бизнес 1920-иод оны эцсээр шахагдан гарсан байна.

Монголын автономит Засгийн газар нийслэл Хүрээнд АНУ-ын консулын газрыг суулгах хүсэлтэй байгаагаа Бээжинд суугаа АНУ-ын Элчин сайдын яаманд 1919 оны 10-р сарын 1-нд илгээсэн захидалдаа:⁶ “. . . бидний Монголчууд бусад гүрнүүдтэй найрамдалт, худалдааны харилцаа тогтоохыг ямагт эрмэлзэж ирэв. Гэвч зам хол, Хиагтын гэрээнээс шалтгаалан Монголын ард түмний хүсэл зориг биелсэнгүй. Үүний зэрэгцээ танай зарим иргэд манай Өргөөнд ирж суурьшин арилжаа эрхэлж байна. . . . Манай энэхүү хүсэлтийг болгоон аугаа их Америкийн засгийн газар Өргөөд консул аль болох түргэн илгээхийн тулд таныг Хятадын Засгийн газартай шаардлагатай бүхнийг зохицохыг хичээнгүйлэн хүснэ. Америк хүмүүстэй арилжаа хийхэд Америкийн консул тусална. . .” гэж бичсэн нь АНУ-ын консулын газрыг ажиллуулах, Монгол, АНУ-ын хооронд худалдаа, арилжаа эрхлэж явуулах чин хүсэлтэй байсны илрэл юм.

1920-1922 онуудад Тяньжинд суугаа Ерөнхий консул Эберхардт, Хаалганд суугаа консул Сокобин нар хэд хэдэн удаа Хүрээнд ирж Монгол орны улс төр, эдийн засгийн талаар судалгаа хийж засгийн газартаа танилцуулж байжээ. Эдгээр консулуудтай Богд хааны даалгавраар Жалханз хутагт Дамдиндорж, Дилав хутагт Жамсранжав нар биечлэн уулзаж “Монголын өмнөөс Хятадын Засгийн газартай уулзаж автономит эрхийг эгүүлэн олгох талаар ярилцах, Монголыг өмгөөлөлдөө авах” талаар хүсэлт тавьжээ. Гэвч АНУ-ын Засгийн газар албан ёсны хариу өгөөгүй байна.

Тус захидал нь хоёр орчим хуудас бөгөөд Богд хаант Монгол Улсын засгийн газраас АНУ-ын Засгийн газарт хандаж гаргасан албан захидлуудаас хэмжээ, агуулгын хувьд тухайн үедээ нарийн утга учрыг тайлбарласан чухал захиал байсан гэж үзэж болно. Захидлын эхний хэсэгт жирийн амьдарч буй малчин ардууд амьдрал ахуйгаа эрхэлсээр ирсэн тухай, манжийн эрх мэдэлтнүүд шинэ дэглэм тогтоосон тул мал ахуй цөөрч, монгол газар нутгийг анжсаар сэглэж, хятад хүнтэй цус холилдох явдал хирээс хэтэрч, Монголчуудын ахуй амьдрал орвонгоороо доройтон муудаж байгаа тул Богд хаант Монгол Улсын Засгийн газар үндэсний эрх чөлөөг эрхэмлэн Орос улсаас тусламж, туслалцаа эрэлхийлсэн тухай мөн Хятад, Оростой гэрээ, хэлэлцээр байгуулж автономит өөртөө засан тогтнох эрхтэй болсон тухай дурджээ. Түүнчлэн Орос өмнө нь байгуулсан гэрээ, хэлэлцээрээ зөрчин Монголыг нууц байдалтайгаар Хятадад дагаар оруулж, улмаар Хятад Улс цэргийн хүчээр Монголыг эзэрхийлэн түрэмгийлж, автономит эрхийг цуцалж, ард иргэдийг айлган сүрдүүлж байсан тухай өгүүлээд: “. . . Энэ үед, бид манай улсад консул илгээн ажиллуулах, Америк манай Монголын ард түмний хооронд нөхөрсөг харилцааг тогтоох, хүсэлтийг Америкийн ард түмэнд захидлаар илгээсэн. Энэхүү захиаг Бээжин дэх Америкийн Засгийн газарт хүргүүлсэн, энэ үетэй давхцан

⁶ Р. Болд “Монголын тусгаар тогтнол ба Америкийн нэгдсэн улс” УБ 2008, 361-р тал

Хятад Улсын генерал Сүй Шүжин манай улсад ирсэн ба Хятад, Оросын хооронд байгуулсан гэрээг хүчингүй болгож, Богд хааны ордныг түүний цэргүүд бүслэн хаах, Богд гэгээнийг баривчлан хорих, төрийн сайд, ноёдод дарамт учруулах цэрэг үйлдлийг хийж байсан болой.” гэжээ. Хятадын Засгийн газар гурван улсын хооронд байгуулсан хэлэлцээрийг хүчингүй болгосон бичгийг үзүүлж түүнд гарын үсгээ зурахыг шаардаж байжээ. Тэрээр аргагүй хүчинд автагдан гарын үсэг зурсан байна. Түүнчлэн Хятадын генерал Сүй Шүжан Монголын ард түмнийг хууран мэхэлж, тэдэнд бүх талын туслалцаа үзүүлнэ гэсэн худал ухуулах хуудас тарааж байсан тухай тус захидалд дурджээ.

Тус захидлын сүүлийн хэсэгт: “. . . Манай Улсад үүсээд байгаа нөхцөл байдалд ямар нэг зүйл хийх чадал мөхсөдөж байсан энэ үед манай нийслэл Өргөөнд танай нигүүлсэнгүй ард түмний төлөөлөгч ноён Чарлас К.Эберхардт, Америкийн ерөнхий консул ирэх үеэр бидэнд энэхүү айлтгалыг танай сайн Засгийн газар болоод танд өргөн барих завшаан тохиосон ба манай улсын талаар гэгээн оюундаа тунгаан үзэх, манай автономит эрхийг эргүүлэн бидэнд буцаан авахад туслалцаа үзүүлнэ үү хэмээн гуйн айлтгаж байна.” гэж бичсэн байна. Тийнхүү Богд хаант Засгийн газар АНУ-ын Засгийн газраас Монголыг өмгөөлөлдөө авч, Богд хаант засаглалыг эргүүлэн тохиуулах, гадаадын хулгай дээрэмчин, цэргийн хүчнээс чөлөөлж өгөхийг хүссэн байна. Гэвч тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Богд хаант Монгол Улсад АНУ нь бодитой туслалцаа үзүүлж чадаагүй юм. Үүний учир нь Азид явуулж байсан АНУ-ын гадаад бодлоготой холбоотой. АНУ-ын Ази дахь ашиг сонирхол бол Манжийн дарлалаас чөлөөлөгдөөд удаагүй байсан Хятадыг өөрийн холбоотон болгох явдал байлаа. Үүний тулд АНУ-ын Засгийн газар олон тэрбум долларын туслалцааг Хятадын Засгийн газарт үзүүлж байсан явдал юм. Энэ тухай АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Дийн Раск гурав орчим тэрбум долларын туслалцааг Чан Кайшигийн Хятадын цэрэг арми, зэр зэвсэг болон эдийн засгийг дэмжлэг үзүүлж байсан талаар дурдсан байдаг.

Хятадын талаар баримталж байсан АНУ-ын бодлого нь тус орны бүрэн бүтэн байдлыг дэмжих явдал байв. Өөрөөр хэлвэл Дундад Иргэн Улс, Ар Монголыг өөрийн бүрэлдүүн хэсэг гэж үзэж байсныг дэмжиж байсан явдал юм. 1914 оны АНУ-ын Засгийг газарт Богд хаант Монгол Улсаас хоёр орны хооронд найрамдал, найрсаг харилцаа тогтоон, арилжаа наймаа хөгжүүлэн, хамтран ажиллах тухай санал дэвшүүлсэн захидал илгээсэн боловч АНУ түүнээс татгалзах байр, суурь баримталж, Хятадын Гадаад Явдлын яамтай энэ асуудлыг зөвлөлдөн шийдэхийг Элчин сайдын яамандаа даалгасан байдаг. Энэ нь Хятадын Монголын талаарх байр суурийг харгалзан үзсэний дагуу түүнтэй хэрхэн харьцахаа шийднэ гэсэн үг байлаа. Дээрх захидалд Богд хаант Монгол Улсын байдал маш хүнд байдалд орж Хятадын цэргийн талхидалд Монголын ард түмэн нэрвэгдэж, автономит эрхээ алдсан хэцүү цаг үе байсан тухай дурджээ. Иймд үед Монголын удирдагчид бусад гуравдагч хөрш улсуудаас тусламж туслалцаа хүссэн боловч Оросоос өөр гар сунгасан улс үгүй билээ.

1919 оны 11-р сард Жалханз Хутагт Дамдиндорж АНУ-ын дипломат Теннейтэй биечлэн уулзсан анхны төрийн дээд албан тушаалтан байсан бөгөөд Ар Монголыг хамгаалалтдаа авч, Монголын талаар нааштай байр суурь баримтлах талаар Хятадын засгийн газартай ярьж, зуучилж өгөх, Хүрээнд АНУ-ын консулын газрыг нээн ажиллуулах талаар арга хэмжээ авах талаар Богдын илгээсэн захидлыг үндэслэн ярьсан байна. Гэвч АНУ-ын Засгийн газар нэгэнт Хаалганд консулын газраа нээсэн тул Хүрээнд консулын газар нээх шаардлагагүй гэж үзэж байсан юм. Худалдаа, эдийн засгийн харилцаа эрчимтэй болтол байдлыг ажиглах хандлагатай байсан гэж үзэж болно. Ийнхүү Монгол оронд улс төрийн байдал тогтворгүй, ээдрээтэй, цэрэг дайны үйл ажиллагаа өрнөж байсаар 1921 онтой золголоо.

1921 оны 7-р сард Монгол оронд Ардын хувьсгал ялсны дараа 9-р сард Богд гэгээн АНУ-ын консул С. Сокобинд Хятад, Монголын харилцаанд дайсагнал үүсэж найрамдалт үйл хэрэгт хир суусан тул энэ хэргийг зохицуулахад АНУ-ыг зуучилж өгөхийг хүссэн захидал илгээсэн байна. Түүний дараахан Ерөнхий сайдын албан тушаалд томилогдсон Бодоо АНУ-ын төрийн нарийн бичгийн даргад бас нэг захиаг 1921 оны 9-р сарын 12-д илгээсэн байдаг. Захидлын эхэнд Хятадын цэргийн түрэмгийлэл Монгол оронд нэвтрэн орж, улс, ардыг үймээн түйвээж байсаныг үлдэн хөөхийн сацуу цагаантны хулгай дээрэмчин Барон Унгернг зайлуулан цаазалж, Богд хаанаа ширээнд нь эргүүлэн залж, ардын засгийн газрыг эмхлэн байгуулсан тухай дурдаад: “. . . Мей улсын Засгийн газраас манай монголын ардын засгийн газар лугаа эртхэн гэрээ байгуулж, элчин сайд суулгаж худалдаа, арилжааг улмаар бадруулан хоёр этгээдийн ашиг тусыг хөгжүүлэхийг хүсэж буй тул эрхэм их сайд та байцаан тулж даруйхан баяртай хариу хүртээх ажаамуу.” гэж бичжээ.

Энэ мэтээр тухайн үеийн Монголын удаа дараагийн Засгийн газрууд АНУ-тай дипломат харилцаа тогтоон, өөрийн улсын тусгаар тогтнолыг олон улсын тавцанд их гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлэх, хоёр орны хооронд худалдаа, арилжааг өргөжүүлэн тэлэх, Хүрээнд консулын газар нээн ажиллуулах, элчин төлөөлөгчид солилцох зэрэг асуудлыг хөндөн тавьсан боловч Хятад улс Монголыг өөрийн нэг хэсэг, тусгаар тогтносон орон биш гэж үзэж байсан зэргээс шалтгаалан АНУ нааштай хариу өгөөгүй юм. Зөвлөлтийн нөлөөлөл Монголд хүчтэй нэвтрэн орж гадаад харилцааг боймлох хүртэл манай талаас АНУ-ын талд хандан дипломат харилцаа тогтоон хамтран ажиллах санал санаачилгыг байнга гаргаж байсан байна.

1921 оны сүүлчээр Вашингтонд хуралдсан есөн улсын бага хурлаас Хятадын талаар баримтлах дөрвөн зарчмын 1-рт “Хятадын бүрэн эрх, тусгаар тогтнол, газар нутгийн болон засаг захиргааны халдашгүй байдлыг хүндэтгэнэ” гэсэн зарчмыг удирдлага болгон АНУ нь Ар Монголыг Хятадын нэг хэсэг гэж үзэж байсан⁷ тул Монголын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хүлээн зөвшөөрөхөөс булзаж байсан юм.

Дэлхийн улс орнуудаас хамгийн түрүүнд Зөвлөлт Орос Улс, Монгол Улсын

⁷ М. Хурметхан, Монгол Америкийн харилцаа ба Америк судлал, 15-р тал

тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч 1921 оны 11-р сарын 5-нд “Найрсаг харилцаа тогтоох гэрээ”-г байгуулжээ. Гэвч Зөвлөлт-Хятадын хооронд 1921 оны 12-р сараас эхэлж хэдэн жил сунжирсан хэлэлцээрээр Зөвлөлтийн тал эхэн үедээ Монгол-Оросын 1921 оны энэ гэрээний байр сууриа хадгалахыг мэдэгдэж байсан боловч “Хятадын болон Дорно дахины хувьсгалт хөдөлгөөний зорилго, эрх ашгийг хамгаалах үүднээс” гэсэн шалтаг зааж, улмаар Бээжинд 1924 оны 5-р сарын 31-нд “Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс (ЗСБНХУ) ба Дундад Иргэн Улс (ДИУ)-ын хоорондын асуудлыг зохицуулах ерөнхий зарчмуудын тухай” гэгч хэлэлцээрт “*Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс нь Гадаад Монголыг Дундад Иргэн Улсын бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрч Дундад Иргэн Улсын тэндэх бүрэн эрхийг хүндэтгэнэ*”⁸ гэсэн заалт оруулсан нь дэлхийн улс гүрнүүд Монгол Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөд маш ихээр саад тотгор болсоор ирсэн юм.

1920-иод оны дундуур Монгол-АНУ-ын харилцаанд гарсан томоохон онцлог үйл явдал бол АНУ-ын эрдэмтэн, Төв Азийг судлах шинжилгээний ангийн удирдагч Рой Чэпмэн Эндрюс Монголын говиос үлэг гүрвэлийн өндөг, араг ясыг олсон явдал юм. Энэ нь дэлхий дахиныг гайхшируулж бөглүү, хаагдмал Монгол орныг дэлхий дахинд таниулж өгсөн билээ. Мөн АНУ-ын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Хербэрт Хүүвэр ХХ зууны эхээр залуу ахуй үедээ Монголд айлчилж Богд Гэгээнтэй уулзаж байсан нь сонирхол татахуйц үйл явдал байсан.

1911 оны эрх чөлөөний хөдөлгөөнөөс хойш 1920-иод оны эцэс хүртэл Монгол Улс, АНУ-ын хооронд албаны хүмүүсийн албан ба албан бус айлчлал, худалдаа, бизнесийн ажиллагаа нэлээд идэвхтэй өрнөж байсан боловч хөрөнгөтний бус хөгжлийн зам гэгчийг заасан МАХН-ын III их хурлаас /1924/ хойш БНМАУ-ын барууны орнуудтай харилцах аливаа харилцааг хааж, худалдаа, бизнесийн үйл ажиллагааг элдэв аргаар шахан зайлуулах бодлого явуулж, 1929 онд гадаад худалдааны онц эрхийг тогтоосноор 20-оид оны сүүлч, 30-аад оны эхээр Монгол, АНУ-ын худалдаа, эдийн засгийн харилцаа тасарч, Монгол дахь АНУ-ын пүүсүүд хаагдаж, Монголын талаарх улс төр, худалдааны хүрээн дэх АНУ-ын ашиг сонирхлыг бууруулав. Энэ нь Монголын зах зээлд ЗХУ өөрөө дангаараа ноёрхох гэсэн бодлогын үр дагавар байлаа.⁹

АНУ-ын дэд Ерөнхийлөгчийн айлчлал ба Ялтын хэлэлцээр

Ийнхүү Монгол, АНУ-ын харилцаа бүдгэрч, тасалдаж эхэлсэн тэр үеэс хойш арав гаруй жилийн дараа нэгэн онцгой үйл явдал тохиосон нь Монгол оронд 1944 оны 7-р сард АНУ-ын дэд Ерөнхийлөгч Хенри Уоллес айлчлал байв. Х. Уоллес богино хугацааны айлчлалынхаа үеэр ардын урлагийн тоглолт сонирхож, монгол гэрт хонож, монгол үндэсний дээл өмсөж, наадмын үйл ажиллагаанд оролцон, тэр

⁸ Ж. Дашдаваа, Монгол Америкийн харилцааны түүхийн мөрөөр мэдрэхүй, УБ 2017, 119-р тал

⁹ М. Хурметхан, Монгол Америкийн харилцаа ба Америк судлал, 16-р тал

өдөртөө Улаанбаатар хотын “үзэх ёстой” газруудаар орж, Богд хааны зуны ордон болон Гандан хийдэд зочилжээ. Түүнд нум сум, монгол гутал бэлэглэснээс гадна шуудангийн марк цуглуулах дуртай Ерөнхийлөгч Франклин Рузвельтэд дамжуулж өгөөрэй гэж монгол маркийн дээжис гардуулсан ажээ.¹⁰ Дэд Ерөнхийлөгчийг дагалдан нэрт Монголч эрдэмтэн Оуэн Латтимор орчуулагчаар ажилласан юм. АНУ-ын дэд Ерөнхийлөгч Хенри Уоллесийн айлчлалын зорилго нь АНУ-ын Ерөнхийлөгч болон Засгийн газарт Монголын талаар өөрийн үзэл хандлага, мэдээллийг өгөх явдал байлаа.

1945 оны 2-р сард ЗХУ-ын удирдагч И. Сталин, АНУ-ын Ерөнхийлөгч Ф. Рузвельт, Их Британий Ерөнхий сайд У. Черчилль нар Зөвлөлт Холбоот Улсын Крымийн хойг дахь Ялта хотноо хэлэлцээр хийсэн юм. Энэхүү хэлэлцээрээр АНУ-ын хүсэлтээр ЗХУ дэлхийн II дайн дууссаны дараа Японд дайн зарлах, харин ЗХУ-ын нэг болзол нь БНМАУ-ын статусквог Чан Кайшигээр хүлээн зөвшөөрүүлэх үүргийг АНУ-д хүлээлгэсэн юм. ЗСБНХУ, АНУ, Их Британий гаргасан энэхүү түүхэн чухал хэлэлцээрийн шийдвэрт: “Гадаад Монгол /БНМАУ/-ын статусквог хэвээр хадгалахыг заасан нь БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхийг АНУ хүлээн зөвшөөрсөн хэрэг байв. Үүний дараахан 1945 оны 10-р сарын 20-нд Монголын ард түмэн эх орныхоо тусгаар тогтнолыг баталгаажуулахын төлөө орон даяар явуулсан санал хураалтад идэвхтэй оролцож тусгаар тогтносон Монгол эх орныхоо бүрэн эрхт байдлыг санал нэгтэй дэмжиж гарын үсгээ зурцагасан нь чухал түүхэн явдал болсон юм. Иймд Дундад Иргэн Улсын Гадаад Явдлын яамнаас 1946 оны 1-р сарын 5-ны өдөр БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч байгаагаа албан ёсоор илэрхийлж 2-р сарын 13-ны өдөр дипломат харилцаа тогтоов.

БНМАУ-д явагдсан бүх нийтийн санал хураалт нь Монголын ард түмэн тусгаар тогтносон улс гэдгээ нэгэнт нотолсон тул ДИУ тус улсыг өөрийн бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх нь олон улсын эрх зүйн үүднээс хүчингүй зүйл гэж АНУ үзжээ. Түүнээс хойш АНУ БНМАУ-ыг Тайваний бүрэлдэхүүн гэж үзэхгүй байх, түүний статусын талаар эрх зүйн тайлбар хийхгүй байх байр суурийг баримталсан байна.

Дэлхийн II дайны дууссаны дараа 1949 онд Хятадад коммунизм ялж, Чан Кайшигийн Хятад Тайваний аралд хөөгдөн гарсан нь АНУ Хятадыг нөлөөлөлдөө оруулах бодлого нуран унасан юм. 1949 онд Хятадын эх газарт БНХАУ байгуулагдаж манай улстай дипломат харилцаа тогтоов. Үүний дараахнаас Солонгосын дайн эхэлж 3 жил үргэлжилсэн. 1950-иад оны дунд үеэс АНУ-ын Ерөнхийлөгч Эйзенхауэр БНМАУ-ыг сонирхож эрдэмтэн, судлаачид, сонины сурвалжлагч нарыг манай улсад илгээн мэдээлэл авч байлаа. Тэдний олж авсан мэдээ, мэдээлэл нь БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох тухай Ерөнхийлөгч Жон Кеннеди санаачилга гаргахад тодорхой нөлөө үзүүлсэн нь дамжиггүй.

¹⁰ Ж.Эдлтон, АНУ-Монгол Улсын дипломат харилцаа, УБ 2012, 24-р тал

Хүйтэн дайны үед БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох АНУ-ын санаачилгууд

1961 эхээр АНУ-ын Ерөнхийлөгч Жон Кеннеди БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох, НҮБ-д элсүүлэх талаар дүн шинжилгээ хийж танилцуулахыг Төрийн департаментад даалгасан байна. БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох замаар Улаанбаатарт дипломат төлөөлөгчийн газраа байгуулах АНУ-ын зорилго нь Монголын хөрш ЗХУ, БНХАУ-ын хооронд үүссэн зөрчил, зөрөлдөөнийг дундаас нь ажиглан тандах явдал байв. Хоёр социалист их гүрнүүдийн харилцааг тандан мэдсэнээр Азид явуулах гадаад бодлогоо боловсруулахад АНУ-ын хувьд чухал зүйл байсан юм. Гэвч Тайваний Ерөнхийлөгч Чан Кайши, АНУ-ын Конгрессын зарим гишүүдийн эсэргүүцэл, Берлиний хямрал зэрэг тухайн үеийн олон улсын эгзэгтэй, эдрээтэй нөхцөл байдлаас хамааран Улаанбаатарт ДТГ-аа байгуулах АНУ-ын үйл ажиллагаа зогсож, БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох явдал тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон юм.

Үүний дараа 1968 онд АНУ-ын Ерөнхийлөгч Ричард Никсон БНМАУ-тай дипломат харилцаа тогтоох санаачилга дахин гаргасан боловч ЗХУ-ын нөлөөлөл, Вьетнамын дайн зэрэг объектив, субъектив хүчин зүйлсээс хамааран хэрэгжээгүй бөгөөд 1973 онд Ерөнхийлөгч Р.Никсоны засаг захиргаа БНМАУ-тай харилцаа тогтоох шийдвэрийг дахин гаргасан байна. Гэвч ЗХУ-ын засгийн газар БНМАУ, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоож, геополитикийн хувьд чухал цэг болох Монголд АНУ-ын ДТГ-ыг байгуулахад дурамжхан хандаж байсан юм. Өөрөөр хэлбэл Зөвлөлтийн талаас хориг саад хийж байсан юм.

Ийнхүү XX зууны эхнээс улбаатай хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоон, худалдаа бизнесийн ажиллагааг өргөжүүлэн тэлэх оролдлого, санал санаачилга бүтэлгүйтсээр 1987 онтой золгосон бөгөөд гагцхүү энэ онд манай хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоож, бүх салбарт хамтран ажиллаж, харилцан бие биедээ туслах үйл ажиллагааны эхлэл тавигдсан билээ. Анх дипломат харилцаа тогтоосон тэр үеэс 33 жил улиран одоо өдгөө манай хоёр орны харилцаа улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, батлан хамгаалахын салбарт асар хурдан хөгжиж, стратегийн түншлэлийн түвшинд хүрлээ.

ДҮГНЭЛТ

1. Богд Хаант Монгол Улсаас эхлэн удаа дараагийн засгийн газрууд АНУ-аар тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлж дипломат харилцаа тогтоох талаар хэд хэдэн удаа хүсэлт гаргасан боловч АНУ-ын засгийн газраас нааштай хариу аваагүй учир нь АНУ-ын Хятадын нутаг, дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хадгална гэсэн зарчим баримталж байсан явдалтай холбоотой бөгөөд Монголтой харилцаа тогтоох асуудлыг ДИУ-тай зөвшилцөж байж шийднэ гэсэн байр суурь баримталж байв. Өөрөөр хэлбэл АНУ-ын Засгийн газар, ДИУ-тай зөрчилдөхгүйн тулд Монголын тусгаар тогтнолыг хүлээн

зөвшөөрөх байр суурь баримтлаагүй гэж дүгнэж болно.

2. Дэлхийн улс орнуудаас хамгийн түрүүнд Зөвлөлт Орос Улс, Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн ч 1924 онд ЗСБНХУ, ДИУ-ын хооронд байгуулсан хэлэлцээрийн 5-р заалт дэлхийн улс гүрнүүд Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөд саад тогтор болсоор ирсэн юм.
3. 1944 оны АНУ-ын дэд Ерөнхийлөгч Хенри Уоллес айлчлалын зорилго нь 1945 онд болох Ялтын хэлэлцээрт бэлтгэж байсан АНУ-ын засгийн газарт Монголын талаар өөрийн үзэл хандлага, мэдээллийг өгөх явдал байсан юм гэж үзэж болно.
4. 1945 оны 2-р сард ЗСБНХУ, АНУ, Их Британи гурван их гүрний гаргасан энэхүү түүхэн чухал хэлэлцээрийн шийдвэрт: “Гадаад Монгол /БНМАУ/-ын статусквог хэвээр хадгалахыг заасан нь БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхийг АНУ хүлээн зөвшөөрсөн хэрэг байв.
5. 1945 оны 10-р сард Монголын ард түмэн, эх орныхоо тусгаар тогтнолыг баталгаажуулахын төлөө орон даяар явуулсан санал хураалтад идэвхтэй оролцож тусгаар тогтносон Монгол эх орныхоо бүрэн эрхт байдлыг санал нэгтэй дэмжиж гарын үсгээ зурцгаасан нь чухал түүхэн явдал ба Дундад Иргэн Улсын Гадаад Явдлын яамнаас 1946 оны 1-р сард БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоосон тул ДИУ тус улсыг өөрийн бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх нь олон улсын эрх зүйн үүднээс хүчингүй зүйл гэж АНУ үзжээ. Иймд АНУ БНМАУ-ыг Тайваний бүрэлдэхүүн гэж үзэхгүй байх, түүний статусын талаар эрх зүйн тайлбар хийхгүй байх бодлого баримталсан нь БНМАУ-ын талаарх АНУ-ын албан ёсны байр суурь байсан гэж дүгнэж болно.

НОМ ЗҮЙ

- Болд. Р. Америкийн консул Сокобин Монголын тухай, УБ., 2017.
 “Америкийн нэгдсэн улсын ерөнхийлөгчийн засаглал.” ШУА-ын олон улс судлалын хүрээлэн, АНУ-ын элчин сайдын яам
- Баатар.Ц. Глобалчлалын эриний Америкийн эдийн засаг.УБ., 2004.
- Баярхүү. Д. Евроазийн геополитик, олон улсын харилцаа /өнгөрсөн, одоо, ирээдүй/. УБ, 2005.
- Болд.Р. Монголын тусгаар тогтнол ба АНУ /1910-1973/. УБ, 2008.
- Болдбаатар.Ж, Батбаяр. Ц, “Монгол, Хятадын харилцааны түүхийн зарим асуудал.” УБ, 2011.
- Дашзэвэг. Б.“Монгол-Америкийн харилцааны түүхийн чухал асуудал.” УБ, 2010.
- Дэмбэрэл. К. Төв Азийн геополитик-Монгол Улс. УБ, 2005.
- Эдлтон Жонатан. АНУ-Монгол Улсын дипломат харилцаа /1987-2012/. УБ, 2012.
- Ишжамц. Н. АНУ-аас Монголд явуулсан бодлого: Монгол-АНУ-ын харилцаа 1900-1987.

- Хурметхан. М. Монгол Америкийн харилцаа ба Америк судлал. УБ, 2003.
- Хурметхан. М. Монгол Улс-Америкийн нэгдсэн улсын иж бүрэн түншлэлийн эхэн. УБ, 2007.
- Campi Alicia and Baasan.R. The Impact of China and Russia on U.S.-Mongolian Political Relations in the Twentieth Century.
- Kennedy F. John. "US Policy Toward Outer Mongolia". Papers of John F. Kennedy, Presidential Papers, President's Office Files. September 20, 2016. <https://www.jfklibrary.org>
- "Memorandum of Chiang Kai-shek to the U.S. President John F. Kennedy." Papers of John F. Kennedy, Presidential Papers, National Security Files. October 20, 2016. <https://www.jfklibrary.org>
- Memorandum of Conversation, Department of State, Conference Files
- "Telegram from the Department of State to the Embassy in the Republic of China." Department of State, Central Files, FRUS 1961-1965, Volume XXII, North East Asia, (September 2016): <https://history.state.gov>.
- Letter from President Kennedy to President Chiang. Department of State, Presidential Correspondence: Lot 66 D
- "Memorandum from Secretary of State Rusk to President Kennedy." Foreign Relations of the United States, 1961-1963, Volume XXII, North East Asia. (September 2016): <https://history.state.gov>